

Төмөрбаатарын Түвшинжаргал¹,[✉] Дамчаабадгарын Содномжамц²¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн.

Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,

Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Хадны зураг дахь буга унаачид юу өгүүлнэ вэ

Товчлол. Зүүн хойд Азийн бүс нутаг орших эртний нүүдэлчдийн аж амьдрал цаа бугын аж ахуйтай салшгүй нягт холбоотой ч анх хэдий үеэс хаана цаа бугыг гаршуулсан цаашлаад халиун бугыг гаршуулж байсан эсэх асуудал нь судалгааны сонирхолтой сэдэв билээ. Чухам үүнийг нэхэн өгүүлэх археологийн баримт хэрэглэгдэхүүн тун хязгаарлагдмал гэж ойлгож болно. Тэр дундаа халиун бугыг гаршуулж, тээвэрт ашиглаж байсан гэх эртний баримт хэрэглэгдэхүүн одоогоор бараг үгүй билээ. Харин энэ удаад бид Монгол орны хадны зургаас илрүүлсэн буга унасан зургийн судалгаанд анхаарал хандуулж улмаар археологийн бусад баримт дээрх буга унасан, тэргэнд хөллөсөн, нуруу ачсан зургуудтай харьцуулан үзэж, хэлэлцүүлэг өрнүүлэхийг зорив. Гэвч хадны зургийн он цаг тогтоох хүндрэлтэй байдлаас үүдэн хэлэлцүүлж буй сэдэвт зургийг тодорхой нарийн цаг үед хамруулж авч үзэхэд бэрхшээлтэй ч хүрлийн үеэс эртний улсуудын үе хүртэлх өргөн цар хүрээнд холбогдох боломжтой. Эдгээр буга унаачдын зургийг аливаа нэгэн зан үйл, үлгэр домгийн утга агуулгатай, хийсвэр дүрслэл хэмээн тайлбарлаж болох ч нөгөө талаар цаа болон халиун бугыг аж ахуй болон зан үйлийн аль нэг хэлбэрээр уналгад ашиглаж байсныг тодорхойлох өнөөгийн Монгол улсын нутгаас олдож буй анхдагч баримтууд хэмээн үзэв.

Түлхүүр үг. Халиун буга, цаа буга, гаршуулалт, буга унах, хадны зураг

Tuvshinjargal Tumorbaatar¹,[✉] Sodnomjamts Damchaabadgar²¹Institute of Archaeology,

Mongolian Academy of Sciences Building-1.

Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Representation of deer riders in Mongolian petroglyphs and their implications

Abstract. While the domestication of some cervids, such as reindeer (*Rangifer tarandus*), have had a substantial impact on lifeways and societies on Northeast Asian societies would be accurate, there is limited, if any, archaeological evidence for domestication relationships with other cervids such as the Eurasian red deer (*Cervus elaphus*). This paper investigates a series of deer riding images from petroglyphs found in Mongolia including some other archaeological evidence with deer imagery. Although these petroglyph images are not irrefutable evidence they demonstrate a potential domesticate relationship between deer and humans that has largely been neglected in archaeological research and one which could extend into the past. As absolute dating of petroglyph images is imprecise for certain periods, with the lengthy rock-art tradition in Mongolia, deer domestication could have occurred, but this requires further archaeological investigation. These images represent a first step in temporally locating the domestication of deer species in the area. On the one hand, these deer riding images could be an abstract representation of ritual meaning as deer play prominent roles in ancient belief and shaman customs in this region. However, we suggest here that it is likely indicative that both ancient red and reindeer riding was occurring in Altai and Khangai mountains of Mongolia either a real transport or intended taming for ritual activity.

Keywords. Red deer, reindeer, domestication, taming, riding, petroglyph and Mongolia

Удиртгал

Бугын төрөл зүйл дотроос нэгэнт гаршуулж өдгөө тээвэрт ашиглаж байгаа нь цаа буга (*Rangifer tarandus*) юм. Цаа бугыг гаршуулсан хамгийн эртний баримт нь ОХУ-ын Ямало-Ненецийн өөртөө засах тойргийн хэд хэдэн дурсгалт газраас илрүүлсэн цаа бугын ногтны “L” хэлбэрийн эвэр эдлэл, эргүүлэг зэрэг болж буй бөгөөд эдгээр олдвор хэрэглэгдэхүүн нь одоогоос 2000 орчим жилийн тэртээ буюу НТӨ 260 - НТ 140 онд хамаардаг [Losey et al. 2020] бол Хятад сурвалжид дурдагдсан хамгийн эртний бичмэл түүхийн мэдээ 499 онд холбогддог аж [Laufer 1917]. Мөн Хакасын нутагт байх Боярын алдартай хадны зурагт модон байшин, гэр бүхий эртний отгыг мал ахуй, сэнжтэй сав суулга, хүмүүстэй цогцоор нь зурсан зургийг [Дэвлет 1976] буга гаршуулалтын нэгэн баримт болгон үздэг. Учир нь тус зургийн доод хэсэгт модон байшин руу цувж яваа олон буга тэдгээрийг тууж яваа морь, буга унасан хүмүүсийг дүрсэлсэн хэмээн тайлбарладаг (Зураг 2) ба тухайн судлаач тус зургийг Тагарын соёлын хожуу үе буюу НТӨ II-I зуунд хамаатуулж авч үзжээ [Дэвлет 1976: 14, 16. Табл. V-1]. Хакасын нутгаас олдсон өөр нэгэн баримт бол Чаа-тас хэмээх газарт малтсан Таштекийн соёлд холбогдох булшнаас бугын дүрстэй модон сийлбэрүүд юм [Кызласов 1952]. Тус булшнаас эр, эм хоёр цаа бугын дүрст модон сийлбэр илэрсэн ба дөрвөн хөлийг угсарч хийсэн, эвэр болон сүүлийг арьс, хялгасаар хийж байсны ул мөр болох нүхтэй, 64-66 см урттай, 45-46 см өндөртэй ажээ. Хамгийн гол баримт нь бугын хошуун дээрх ногтыг товойлгон дүрсэлсэн нь цаа бугыг Саян, Алтайн бүс нутагт Тагар болон Таштекийн соёлын (НТӨ I – НТ IV зуун) үед цаа бугыг унаж байсны баталгаа хэмээн үзсэн байдаг [Кызласов 1952: 41, 49]. Тэрээр мөн цаа бугыг тайгын анчин овог аймгийнхан анх гаршуулсан байх хэмээн үзэж, энэ нь дор хаяж хүрлийн үед холбогдох магадалтай гэсэн санал дэвшүүлжээ [Кызласов 1952: 49].

Харин цаа бугаас бусад төрөл зүйлийн бугыг хүн төрөлхтөн гаршуулж байсан хийгээд гаршуулах ямар нэгэн оролдлого хийж байсан талаарх археологийн баримт хэрэглэгдэхүүн бараг байхгүй гэж хэлж болохоор юм. Харин Монгол орны хадны зурагт буга унасан хүний дүрслэл цөөнгүй тохиолдож байгааг анзаарахгүй өнгөрч болохгүй билээ. Бид нэг бус газрын хадны зургаас буга унасан хүний зургийг шинээр илрүүлэн олж улмаар урьд өмнө хэвлэн нийтлэгдсэн зургуудыг нэгтгэн үзэж, улмаар археологийн бусад мэдээ баримттай харьцуулан эдгээр буга унасан зургууд нь эрт цагт үнэхээр бугыг унаж байв уу гэдэг асуудлыг хэлэлцүүлэхийг зорив. Хэдийгээр тэдгээрийн зарим нь тойм дүрслэлтэй боловч

зарим нь маргахын аргагүй бодит дүрслэлтэй сийлэгдсэн зургууд юм.

Хадны зураг дахь буга унасан хүний дүрслэл

Монгол орны хадны зурагт буга унасан хүний дүрслэл тохиолдож буйг анзааран тэмдэглэсэн судлаачдын нэг нь археологич Т.Санжмятав билээ. Тэрээр Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутаг Их Бэрх уулын хаданд буга унасан хүний зураг байгааг дурдаж улмаар энэ нь бугыг зүтгэх хүчинд сургасан бус өөрсдийн хүсэл мөрөөдлийг уран сэтгэмжээр илэрхийлэн гаргасан урлаг юм гэж үзжээ (Зураг 3а), [Санжмятав 1997: 73; Энхтүвшин, Санжмятав 2006: 16, 20]. Мөн 1995 онд хэвлүүлсэн “Монголын хадны зураг” нэгэн сэдэвт бүтээлийн 249-р хавсралтад зарим буга унасан, хөтөлсөн зургуудыг нэгтгэн авч үзсэн байдаг [Санжмятав 1995: табл 249]. Тэдгээрийн 1 болон 7, 9-10 дахь зургуудыг буга унасан зураг гэж үзэж болохоор юм (Зураг 3b-d). Нягтлан үзэхэд тус номын 249-р таблицы 1-рт байгаа зураг нь Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын хадны зураг болох нь мэдэгдэж буй (Зураг 3d) бол 9-р зураг нь Архангай аймгийн Чулуут голын Салхитын хясааны урд тохойн хадны зураг аж (Зураг 3с), [Санжмятав 1995: 30, Табл. 69]. Мөн тус зурагтай хамт толгой дээрээ салаа эвэр хатгасан мэт хүн буга хөтлөн зогсох бөгөөд хажууд нь өөр нэг буга унасан бололтой хүнийг хамт дүрсэлсэн байна (Зураг 4е). Харин бусад зургийн олдсон газрын талаар тодорхой мэдээлэл байсангүй. Тэвш уулын буга унасан зургийг анх Оросын археологич А.П.Окладников [1980] нийтлүүлсэн. Уг зурагт буга унаж, хоёр гараа өргөсөн хүнийг дүрсэлсэн бөгөөд хүний хөл бугын биеэс доош унжаагүй. Бугыг эвэргүй, оготор богино сүүлтэй, соотон чихтэй, сэрвээг үл мэдэг өндөр, хоёр хөлтэй харьцангуй бодит дүрсэлсэн төдийгүй эр хүйсийг тодотгон харуулсан онцлогтой. Тус бугын доод талын хаданд хараа (эвэрний 1 болон 2-р салаа мөчир) бүхий эвэртэй, эр бугыг хамт сийлсэн байна [Мөн тэнд: 41].

Мөн археологич Д.Цэвээндорж буга унасан хүний дүрслэл ховор боловч Монголын хадны зурагт тохиолддог сэдвийн нэг хэмээжээ [Цэвээндорж нар. 2010: 60, 375]. Тэрээр Увс аймгийн Сагил сумын нутаг Цагаан-Өтөгийн хадны зургаас буга унаж, жадаар зэвсэглэсэн хүний зураг (Зураг 3е), [Цэвээндорж 2019: 107, 375], Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Шивээт хайрханы Хар салаа III дурсгалт газраас илрүүлсэн хоёр том чихтэй марал буга унасан хүний зураг (Зураг 3f), [Цэвээндорж нар. 2010: 60,169, зур. 306], Говь-Алтай аймгийн Ловонгийн нуруунаас дөрвөн янгирын (эвэргүй ишиг) хажууд өргөн том далбагар эвэртэй бугыг зайдан

унасан хүний дүрслэл (Зураг 3g), [Цэвээндорж, Баасандорж 2008: 104, зур. 13-7] зэргийг тус бүр илрүүлжээ. Түүнчлэн Шивээт хайрханы Хар салаа VI дурсгал газрын хадны зурагт гадна тэгийг хөвөөлж зурсан, богино эвэртэй бугыг зайдан унасан хүн (магадгүй нум барьсан) гэж үзэж болохуйц өөр нэг дүрслэл байна (Зураг 3h), [Цэвээндорж нар. 2010: 252, зур. 645].

Дээр өгүүлсэн зургуудаас гадна өөр хэд хэдэн газрын хадны зурагт буга унасан зургууд тохиолдож байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Цагаан салаа IV дурсгалт газраас илрүүлсэн нэг дор дүрсэлсэн буга болон бусад өөр 2 амьтан унасан хүн мэт дүрслэл (Зураг 3i), [Кубарев и др. 2005: 287, Табл-I 604], Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Цэнгэл хайрхан уулын орчмоос илрүүлсэн бугыг жолоодон унаж буй зураг (Зураг 3j), [Бүрэнтөгс 2020: 58, Зураг 1.15], Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Ягаан Орой хэмээх газрын хадны зураг дахь нэгэн буга унасан бололтой хүний дүрслэл (Зураг 3k), [Баасандорж 2018: 26], Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Далан түргэний хос толгойн урт хошуутай, том нүдтэй буган хөшөөний бугатай ойролцоо дүрслэлтэй буга унасан хүний зураг (Зураг 3l), [Kortum 2018: 86] зэрэг дүрслэлүүдийг судлаачид нийтлүүлсэн байна. Дээрх буганы унасан хүний зурагтай ижил бугын дүрслэл тус хадны зургийн дурсгалт газарт мөн тааралдаж байна [Цэрэндагва, Цэвээндорж 2016: 160, Хавсралт 1, 103]. Үүнээс гадна Далан түргэний хос толгойн хадны зурагт цаа буга унасан хүн дүрсэлсэн мэт харагдах нэгэн зураг бий [Цэрэндагва, Цэвээндорж 2016: 116, хавсралт 1, 137] хэмээн тэмдэглэсэн байдаг ч дүрслэлийн хувьд тодорхой бус юм. Цагаан салаа Бага-Ойгорын хадны зургийн Бага-Ойгор III хэсэгт дэх хоёр хүн моринд сундлан давхиж буй морины дүрс хэмээн судлаачдын тайлбарласан зураг сонирхол бас татаж байна [Кубарев и др. 2005: 36, 393, Табл-I. 1035]. Учир нь тус адуу хэмээн тодорхойлсон амьтны сүүл богино ба эвэргүй болохоос биеийн хэлбэр хийц бугатай төстэй харагдана. Ялангуяа дугуйрсан хондлой, хойд хөл, гуяын загвар болон хүзүүний чихлуур хэсэг нарийхан зэргээс харахад буга гэж үзэж болохоор байна (Зураг 3m). Өнөөгийн Монгол Улсаас гадна ОХУ-ын Уулын Алтайн Хатан голын баруун цутгал Чуя голын савд орших Калбак-Ташийн хадны зурагт сагсгар хувцастай нэгэн хүнийг эвэргүй буга унасан мэтээр дүрсэлжээ (Зураг 3n), [Кубарев 2011: 166, табл. 150]. Тус хүний хувцасны хормойн доод хэсгийн цацаг мэт унжлага нь бугын нурууг дарсан байдалтай байгаа нь тус зургийг давхардуулж зурсан гэхээс илүү унасан гэх сэтгэгдэл төрүүлнэ.

2018 онд Баянхонгор аймгийн Өлзийт суманд

ажилласан Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” археологийн хээрийн шинжилгээний ангийн [Батсайхан нар. 2019] хүрээнд Чулуун онгоцот хэмээх газраас буга унасан хүний маш тодорхой нэгэн зургийг илрүүлэн олжээ. Тус буга унасан хүний дээд хэсэгт нэг тэмээг хамт дүрсэлсэн. Буга нь хоёр соотон чихтэй улмаар нэг чихнээс дээш үргэлжлүүлэн хараа бүхий дөрвөн салаа I эвэртэй, оготор богино сүүл, дөрвөн хөлтэйгөөр дүрслэгджээ. Унасан хүн нь нэг гараараа бугыг жолоодож буй мэт урагш хандуулсан бол нөгөө гараа ташуурдах гэж буй бололтой арагш нь хаясан, харин хүний хөл бугын эх биеэс доош унжаагүй байх аж (Зураг 3o). Мөн Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Асган хондны нэгэн хаданд нэг дор ижил загвартай хоёр буга дүрсэлсэн байх бөгөөд тэдгээр бугыг олон салаа хос эвэр, дөрвөн хөл, дээш гозойсон богино сүүлтэй, эр хүйсийг тодотгож, амаа ангайсан байдалтайгаар дүрсэлжээ (Зураг 3p). Харин доод талын бугыг хүн унасан бололтой ба хүний эх бие, толгой тодорхой мэдэгдэж байгаа боловч хүний хөл бугын их биеэс доош унжаагүй, хоёр гарыг мөн тодорхой дүрслээгүй ч буга унасан зураг гэж үзэж болохоор юм.

Он цагийн асуудал

Хадны зургийн он цагийг тогтоох нь нарийн төвөгтэй асуудал байдаг. Хадны зургийн өнгө, элэгдэл, сийлбэрлэсэн багаж, давхардсан байдал, зургийн зохиомж, хэлбэр дүрс, давхардсан байдал, тодорхой амьтны төрөл зүйлийн устаж үгүй болсон цаг хугацаа, буган хөшөө зэрэг он цаг тодорхойлогдсон археологийн дурсгал дээрх дүрслэл, тэрэгний дугуйны хигээс, дөрөөтэй дүрсэлсэн морьтон [Kortum 2018: 22] зэрэг шинж тэмдгүүдийг харгалзан харьцуулан үзэж он цаг тогтоох нь өдгөө ашиглагдаж буй түгээмэл арга зүй гэж хэлж болно.

Далан түргэний хос толгойн хадны зурагт дүрслэгдсэн буган хөшөөний бугын загвартай ижил буюу урт хошуу, том нүдтэй буга унасан хүн (Зураг 3l), Цагаан салаа Бага-Ойгорын хадны зургийн Бага-Ойгор III хэсгээс олдсон хоёр хүн сундалсан бугын ерөнхий загвар (Зураг 3m) болон бусад буга унасан зургийн хамт дүрслэгдсэн зургууд, сийлбэрлэсэн арга барил зэргээс үзвэл эдгээр зургийг хожуу хүрлээс түрүү төмрийн үед хамааруулан үзэж болохоор байна. Түүнчлэн унаачийн хөл унжсан болон унжаагүй байдлыг тодорхойлох замаар он цагийн асуудлыг хөндөж болох талтай. Тухайлбал, морь унасан хүнийг дүрслэхдээ ихэнх тохиолдолд хөлийг нь морины гэдсэн тушаа сул унжуулсан байдлаар дүрсэлсэн байх нь дөрөө үүсэхээс өмнөх үед бүтээгдсэн гэдгийг харуулах баримт гэж зарим судлаач

үздэг [Цэвээндорж нар. 2010: 22; Цэрэндагва, Цэвээндорж 2016: 87-88,90]. Бидний нэгтгэн өгүүлсэн 14 дурсгалт газрын 16 зурагт хүний хөл бугын эх биеэс доош унжаагүй 10 (Зураг 3b-f,i,k,n-p), унжсан гэж үзэж болох 6 (Зураг 3a,g,h,j,l,m) зураг байна. Хөл унжсан 6 зургийн хоёрынх нь хөл цухуйх төдий маш богино (Зураг 3j,i) бол урт унжсан буюу илт зайдан унасан гэж үзэж болох 4 зураг байна (Зураг 3a,g,h,m). Ийнхүү үзэх аваас ихэнх зураг нь төмөр дөрөө бүтээгдсэн цаг үед хамаарах уу эсвэл түрүү төмөр болон хүрлийн үед буга унаачид олс, дээсэн дөрөө бүтээж хэрэглэсэн байх боломжтой юу гэдэг асуултууд урган гарч ирнэ. Нөгөө талаар хөл нь илт унжсан цөөн зургууд нь дөрөө үүсэхээс өмнөх цаг үед бүтээгдсэн байх боломжтой хэдий ч дөрөө бүтээгдсэн үед ч бугыг зайдан унасан байдлаар зурсан байх бас боломжтой. Харин дүрслэлийн хувьд хүрлийн үед хамааруулах боломжтой гэж үзсэн хоёр зурагт хүний хөл унжсан байх ч нэг нь маш богино цухуйх төдий ажээ. Бас нэгэн зайлшгүй дурдах шаардлагатай зүйл бол бугын зураг дээр эдгээр хүнийг унасан мэтээр дараа үед нэмж дүрсэлсэн байх магадлал бий юу гэдэг асуудал юм. Бидний гэрэл зургаас болон өөрсдийн биеэр үзсэн зурагт хожим унасан хүн дүрсэлсэн шинж тэмдэг ажиглагдаагүй. Харин Далан түргэний хос толгойн хадны зураг дахь буга унаач хүний том хамар, толгойн үс зэргийг ажиглавал ихэд өвөрмөц содон харагдах (Зураг 3l) ба цаашид гэрэл зургийг эсвэл дурсгалт газарт очиж нягталж үзэх шаардлагатай санагдана.

Хэлэлцүүлэг

Бид юун түрүүнд буга унасан зургийн цаад агуулга санааг хөндөж, эртний хүмүүс чухам юу илэрхийлэх гэж эдгээрийг зурах болсон тухай зарим судлаачийн дэвшүүлсэн санаа хийгээд өөр юу өгүүлж болох талаар нэмэлт тайлбарыг хэлэлцүүлэхийг зорьсон болно. Үүнд:

1. Археологич Т.Санжмятав гуайн үзсэнчлэн эртний хүмүүс буга унах хүсэл мөрөөдлөө хаданд сийлж, тэмдэглэсэн [1995: 28,93; 1997: 73] байх уу?

2. Бөөгийн зан үйлээр буга нь онгод тэнгэрийн унаа, сүнс тээгч болохын хувьд эдгээр нь хойд насны утга агуулга бүхий хийсвэр дүрслэл байх боломжтой эсэх?

3. Эсвэл үнэхээр бугыг эрт үед хүмүүс унаж, аж ахуйд ашиглаж байсны ул мөр үү гэдэг асуултууд урган гарч байна.

Хадны зураг нь ямар нэгэн утга агуулгагүй, энд тэнд санамсаргүй зурсан зүйл бус [Дорж 1962: 77] бөгөөд тухайн эрт цаг үеийн шүтлэгийн зан үйлийн дагуу сийлсэн тахил тайлга, мөргөл үйлддэг, мөн баяр ёслол тэмдэглэдэг газар [Батболд 2014: 56]

хэмээн ойлгож болох тул тэр бүр зурагт хүсэл мөрөөдлөө тэмдэглэж үлдээсэн гэж үзэх нь тийм ч оновчтой бус тайлбар мэт санагдана. Тэгвэл эдгээр буга унасан зургууд нь нэг бус газраас цөөнгүй тоогоор илэрч олдоод байгаа явдлыг өөр өөр орон зай, цаг хугацаанд хүмүүсийг ижил хүсэл мөрөөдөлтэй байсан гэж үзэхэд хүрнэ.

Нөгөөтээгүүр буга нь тэнгэрийн амьтан, бөө хүний онгодын унаа болдог, сүнс тээдэг, хамгаалагч, өвөг дээдсийн дүр болдог ид шидтэй амьтан гэх зан үйлийн уламжлалт ойлголтууд байдаг бөгөөд буган хөшөөн дээрх бугын дүрс нь тухайн хүний сүнсийг тэнгэрт хүргэгч, хамгаалагч гэсэн утгатай хэмээн олон мэдээ баримтыг нэгтгэн тоймлосон байдаг [Баярсайхан 2017: 85]. Бөөгийн дуудлагад “Халтар халиун буган хүлэгтэнгүүд, Гучин гурван морин хүлэгтэнгүүд...” [Бум-Очир 2002: 55], “Тунам бугын хүлэгтэнгүүд, Гучин хоёр шаргал морин хүлэгтэнгүүд...” [Ренчин 2006: 120] гэхчлэн өгүүлдэг аж. Түүнчлэн зарим бөө төмрөөр хийсэн бугын эвэртэй малгай (оргой) өмсөх төдийгүй эртний оршуулгад бугын эвэр дагалдуулах зан үйл түрүү төмрийн үеийн Пазырык, Чандмань-Сагирын соёлын болон хүннүгийн үеийн булшнаас илэрдэг. Түүгээр зогсохгүй Пазырыкийн булшнаас бугын үс чихсэн эсгий эдлэл илэрч олдсон тохиолдол ч байна [Rudenko 1970, Fig. 56].

Мөн Пазырык булшны оршуулгад дагалдуулсан адуунд бугын маск өмсгөсөн байгаа нь энэ насны унаа болсон адуу нь бугын дүрд хувиран хойд насанд хүргэдэг хэмээх санаа [Түвшинжаргал, Анхсанаа 2023: 99] байж болох юм. Мөн морин тэрэгний урд талд хос болон нэг буга дүрсэлсэн тохиолдол хадны зурагт цөөнгүй тохиолддог (Зураг 4), [Новгородова 1984: 68; Баасандорж 2016: 68; Санжмятав 1995: 28] төдийгүй бугын эвэртэй үхэр, адуу, тэмээний дүрслэлүүд бас байна [Кубарев 2011: 429, 469, 473, 475, 533, 376; Кубарев и др. 2005: Табл-I 522,721; Санжмятав 1995: Табл. 15,49,211; Баасандорж 2016: 72]. Тиймээс энэ мэт эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэлтэй холбоотой хойд насандаа буга унан одож буй хүний сүнс, эсвэл буга унан бууж буй онгодыг хадны зурагт дүрсэлсэн байж болох уу? Бидний цуглуулсан хэрэглэгдэхүүн дотор лавтай зан үйлийн утга агуулгатай байж болох зураг байгаа нь Уулын Алтай дахь Калбак-Ташийн хадны зурагт сагсгар хувцас бүхий буга унасан мэт зураг юм (Зураг 3l). Энэхүү зургаас гадна буга унасан биш ч хүнийг буга, согоотой нэг дор дүрсэлсэн тохиолдол маш олон байгааг харж болно [Кубарев 2011: 116, 166, 169, 182, 196, 210, 214, 303, 344 г.м]. Харин эдгээр буга унаачид чухам ямар төрлийн буга унасан болохыг тодорхойлох нь багагүй төвөгтэй ч эврийн хэлбэрээр цаа буга

эсвэл халиун буга хэмээн тодорхойлж болохоор юм. Учир нь цаа бугын эвэр нь босоо, үзүүр нь урагш бөхийсөн байх төдийгүй эврийн үзүүр өргөн далбагар бол халиун бугын эвэр арагш чиглэлтэй, нарийн шовх үзүүртэй. Энэхүү эврийн хэлбэр ялгаагаар авч үзвэл Говь-Алтай аймгийн Ловонгийн нурууны зургийг цаа буга гэж үзэх боломжтой (Зураг 3г). Их Бэрх, Салхитын хясаа, Цагаан салаа IV, Ягаан орой, Асган хонд (Зураг 3а,с,и,к,р) зэрэг бусад газрын зургийг халиун буга хэмээн тодорхойлж болохоор юм. Харин эвэргүй болон богино эвэртэй буга унасан зургуудын төрөл зүйлийг тодорхойлох боломж бага гэж хэлж болно.

Бугаас гадна Монголын хадны зурагт үхэр унасан хүний дүрслэл элбэг тохиолддог ба үхэр унах нь боломжгүй зүйл биш төдийгүй нүүдэлчид үхэр унасаар ирсэн болохыг түүх, угсаатны зүйн олон баримтаар тодотгон өмнө нь өгүүлсэн билээ [Tuvshinjargal & Makarewicz 2022; Түвшинжаргал 2022]. Тиймээс хадны зураг дахь үхэр болон адуу, тэмээ унасан зураг бүрийг зан үйл, мөрөөдөлтэй холбон тайлбарладаггүйтэй адил буга унасан зургийг нэг өнцгөөс авч үзэх нь нэг талаар өрөөсгөл тайлбар болж магадгүй.

Өөр бусад сонирхолтой баримтын тухай өгүүлэхэд БНХАУ-ын Шандун мужийн Тэнжоу хотын Хуан Анлин хэмээх газраас олдсон Зүүн Хан улсын (20-220 он) үед холбогдох нэгэн бунхны тоосгон дээр буга унасан болон буга хөллөсөн тэргэнд суусан хүмүүсийг дүрсэлжээ (Зураг 5), [Zhu Cunming, Liu Ji 2013: 21]. Мөн үед хамаарах Шандун мужийн Пинян сианаас олдсон буга хөллөсөн тэрэг (Зураг 6), Сичуан мужийн Пэнжоу хотын Жианкоу сиан болон Хэнан мужийн Енчэнгээс олдсон буга унасан хүн (Зураг 7) зэргийг дурдаж болохын зэрэгцээ Шаньси мужийн Суйдэ сианд малтсан бунхнаас сонирхолтой зураг илэрсэн байдаг [Chen Fangyi 2012: 27, 36]. Уг бунхны хаалганы тотгон дээрх зурагт Бомбын шашны өмнө зүгийн сахиус болох улаан божирго шувууны хоёр талд буга унасан нөмрөгтэй хоёр аршийг дүрсэлжээ (Зураг 8). Ерөнхийдөө буга унасан хүн болон буга хөллөсөн тэргэний дүрслэлүүд нь Хан улсын үед өргөн дэлгэрч байсан ч гол сэдвүүдийн нэгт тооцогдох бөгөөд ихэвчлэн бунхны чулуун хананд сийлэгдсэн байгаа нь талийгаачийн хойд насны амьдралтай нягт холбоотой. Буга унасан хүмүүс урт нөмрөгтэй тэнгэрт дүүлэн нисэж буй байдлыг түгээмэл харуулдаг нь дараа ертөнцөд мөнх амьдрахыг бэлгэдсэн утга агуулгатай хэмээн үзэж болох бөгөөд түүнд хүрэх гол унаа нь буга юм. Нөгөө талаар эдгээр зураг нь бунхны хананд дүрслэгдсэн хэдий ч ямар нэг байдлаар бугыг уналга хөллөгөөнд ашиглаж байсныг харуулах

баримт гэж үзвэл энэ нь буга гаршуулалтын эрт үед холбогдох чухал баримтад зүй ёсоор тооцогдоно.

Харин дээрхээс хожуу Ляо улсын (907-1125) үед холбогдох, ӨМӨЗО-ны Тунляо хотын Хүрээ хошууны Нарийн гуу сумын нутгаас 1972 онд олдсон нэгэн бунхны хананд тэргэнд хөллөж буй бугыг харьцангуй бодитоор дүрсэлсэн байдаг. Бунхны 1-р булшны хойд талын хананд “Аянд мордож буй” хэмээх сэдэвт зурагт нийт 29 тооны хүн, тэрэг, буга, адуу зэргийг зурсны дотор гэр тэргэнд буга хөллөж буй гурван хүнийг өнгөөр ялган уран сайхан дүрсэлжээ (Зураг 9а), [Sun Jiahua 2009: 220-221]. Тус ханын зурагт ногтолсон бугын цулбуураас нэг хүн дарж, өөр нэг хүн тэргэний арал буулгыг өргөн хөллөх гэж буйгаар дүрсэлсэн байна. Нэг талаас тус зургийг зөвхөн оршуулгад зориулсан зан үйлийн дагуу уран сэтгэмжээр зурсан байж болох ч нөгөө талаас оршуулгын явцад болсон үйл явцыг тэмдэглэж үлдээсэн байж магадгүй. Учир нь бугын ногт, ногтны уясан сагалдарга, цулбуур, тохош зэрэг тоног хэрэглэл, бугыг тэргэнд хөллөхөөр завдаж хүмүүсийн үйл хөдлөл зэрэг нь бодит мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Түүнчлэн нуруу ачсан бугын дүрслэлтэй хүрэл толь Монголын Үндэсний музейд хадгалагдаж байна (Зураг 9б). Ийм толь өмнөд хөршийн нутагт малтсан Алтан улс болон Юань улсын үеийн дурсгалаас цөөнгүй илэрч олддог ажээ [Guo Yuhai 1996: 157]. Энэ толин дээрх дүрслэл нь дундад зууны үеийн дорно дахины ард түмний дунд уламжлагдан дэлгэрсэн Хэлү тунчун (鶴鹿同春), Магу Сианшуо (麻姑献寿) зэрэг үлгэрийн сэдэв [Tan Xiao, 2018: 57] бөгөөд Бумбын шашны үзэл санаа ихэд шингэсэн аж. Өөрөөр хэлбэр хоёр өөр үлгэрийн сэдвийг хамтад нь нэг толин дээр дүрсэлсэн бөгөөд тогоруу (鶴-he) нь тэнгэрийг, буга (鹿-lu) нь газрыг, хавар (春-chun) нь цэцэг ургамал дэлгэрэх бэлгэдэл агуулахын зэрэгцээ эдгээр нь нийлээд тэнгэрийн доорх бүхэн өнө удаан мандан бадрахын бэлгэдэл агуулдаг байна.

Эдгээр зураг нь хэдийгээр бунхны хананд дүрслэгдсэн байгаа ч зарим зургийн бодит мэт дүрслэлээс үзвэл оршуулгын аливаа үйл явцыг тэмдэглэж зурсан байх магадлалтай. Дэлхий дахинд зэрлэг амьтныг (төл) номхруулж гэрийн амьтан болгосон түүх маш их бөгөөд хүний санаанд оромгүй амьтдыг ч гэрийн болгосон байдаг аж [Даймонд 2023: 216]. Энэ нь мал гаршуулалтаас өөр үзэгдэл билээ. Тухайлбал, японы Айнү үндэстнүүд хүрэн баавгайг бамбарууш байхад нь барьж номхруулаад, шашны ёслол үйлдэн нядалж идэх зорилгоор тэжээдэг байсан гэнэ [Даймонд 2023: 217]. Тэгвэл бугыг ийм зорилгоор магадгүй оршуулгын зан үйлд зориулан зэрлэг бугыг гэршүүлдэг байх магадлал бас байж болох юм.

Онолын хувьд хүн төрөлхтөн бугын төрөл зүйл дотроос зөвхөн цаа бугыг гаршуулсан бус өөр төрөл зүйлийн бугыг ч гаршуулах оролдлого хийж байсан байх магадлалтай. Ер нь халиун бугыг огт гаршуулж болохгүй амьтан гэвэл үгүй юм. Зарим жишээ дурдахад Монгол улсад гэхэд бугын эвэр болон бусад түүхий эдийг авах зорилготой цөөнгүй сангийн аж ахуй байгуулагдаж байсан түүх бий. Ингэхдээ нялх илийг цөөн хоногтой байхад нь барьж гаршуулж байсан бөгөөд буга нь хүнд амархан дасдаг амьтан болохыг дурджээ [Бүүвэй 2019: 65,80]. Магадгүй халиун бугын эвэр арагш ургадаг, нарийн шовх үзүүртэй учир хүн унахад ихээхэн саад төвөг болох төдийгүй, бэртэж гэмтэх ч эрсдэлтэй. Мөн зарим судлаачид яагаад олон төрлийн том хөхтөн амьтан гаршуулагдаагүй талаар дүгнэхдээ өвс тэжээл, өсөлтийн хурд, зан авир, цочиж зугтах хандлага, сүргийн бүтэц, хашиж үржүүлэхэд гарах бэрхшээл зэрэг олон хүчин зүйлийг дурджээ [Даймонд 2023: 221-229]. Энэ мэт биологийн онцлогоос хамаарч халиун буга гаршуулах үйл явц өргөн цар хүрээнд тархаагүй буюу хожуу үе хүртэл уламжлагдаж үлдээгүй байх магадлалтай.

Дүгнэлт

Бид Монголын хадны зурагт тохиолдож буй буга унаачдын зургийг зайлшгүй анхаарч үзэх баримт хэрэглэгдэхүүн хэмээн үзэж, нийт 14 газраас олдсон 16 зургийг нэгтгэн авч эдгээр зургийн агуулга, утга санаа юу өгүүлэх тухай хэлэлцүүлэхийн зэрэгцээ бунхны ханын зураг зэрэг бусад археологийн баримт хэрэглэгдэхүүнтэй харгалдуулан үзэв. Чухам хадны зургийн он цаг тодорхойлох төвөгтэй байдлаас үүдэн нарийвчлан хугацаа заах боломж хомс байгаа ч энэ нь буга унаачдын зургийн шинжлэх ухааны үнэ цэнийг бууруулахгүй нь ойлгомжтой. Учир нь эрт үед өнөөгийн Монгол улсын нутагт буга унах үйл явц ямар нэгэн хэлбэрээр, тодорхой нэгэн цаг үед оршиж байсныг илэрхийлэх анхдагч баримт юм. Он цагийн өргөн цар хүрээгээр авч үзэхэд хүрлийн үеэс эртний улсуудын үе хүртэлх хугацаанд холбогдох боломжтой. Мөн Хан улс, Хятан улсын үеийн бунхны ханын зураг дахь буга унасан, тэргэнд хөллөсөн зургууд болон Юань гүрний үед хамаарах толин дээрх нуруу ачсан дүрслэлүүд эртний нийгэмд буга унах тухай ойлголт байсныг давхар нотолно.

Хэдийгээр буга нь эртний анчид, нүүдэлчдийн хувьд шүтлэг бишрэлийн чухал амьтан, хийсвэр орон зайн унаа болдог ч нөгөө талаар эдгээр хадны зургийн баримтууд нь цаа болон халиун бугыг эрт үед өнөөгийн Алтай, Хангайн уулсын бүс нутагт унаж байсныг илэрхийлж болзошгүй

хэмээн үзэж байна. Боломжит хувилбараар бодож үзэхэд буга нь шүтлэг бишрэлийн чухал амьтан болсон хүрлийн үеэс тэдгээрийг гэршүүлэх болон гаршуулах үйл явц давхар өрнөж байсан байж магадгүй. Гэвч энэ нь аж ахуйн зориулалтаар эсвэл эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, зан үйлийн хэлбэрээр гаршуулсан буга унаачид байж болох гэсэн хоёр салаа дүгнэлтэд хүрч харин төсөөллийн хийсвэр дүрслэл гэдэг тайлбарыг үгүйсгэх санал дэвшүүлэв. Эцэст нь тэмдэглэхэд буга гаршуулалт хийгээд буга унах асуудал нь ганцхан хадны зургийн баримтаар шийдвэрлэгдэх асуудал биш бөгөөд цаашид археологийн олон төрлийн баримт судалгаа шаардагдах сэдэв билээ. Харин өөр баримтаар энэхүү сэдэв дахин хөндөгдөх үед бидний энд өгүүлэн буй хадны зургууд хавсарга чухал баримт болох нь эргэлзээгүй.

Ном зүй

Баасандорж 2016 – Г.Баасандорж. Ловонгийн нурууны хадны зураг. Улаанбаатар, 2016.

Баасандорж 2018 – Г.Баасандорж. Баян уулын хадны зураг. Улаанбаатар, 2018.

Батболд 2014 – Н.Батболд. Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. УБ., 2014.

Батсайхан нар. 2019 – З.Батсайхан., Ч.Амарбилэг., Д.Содномжамц., С.Тэргүүнбаяр. Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” археологийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2019.

Баярсайхан 2017 – Ж.Баярсайхан. Монголын умард нутгийн буган хөшөөд. УБ., 2017.

Бум-Очир 2002 – Д.Бум-Очир. Монгол бөөгийн зан үйл. Улаанбаатар 2002.

Бүрэнтөгс 2020 – Г.Бүрэнтөгс. Цагаан Асга ууланд шинээр бүртгэн баримтжуулсан хадны зургийн судалгаа. Нүүдэлчдийн өв судлал XXII-II, Fasc 5, т. 56-63.

Бүүвэй 2019 – Ч.Бүүвэй. Халиун буга гаршуулах, эвэр боловсруулах арга технологи. Улаанбаатар, 2019.

Даймонд 2023 – Ж.Даймонд. Буу, нян, ган: Хүний нийгмүүдмийн хувь тавилан. Орчуулсан Г.Сугиррагчаа. Улаанбаатар, 2023.

Дорж 1962 – Д.Дорж. Монгол орны хад чулуун дээрх зураг сүгийн зүйл. //Studia Historica. Tom II, Fasc 8. Улаанбаатар, 1962, т. 75-88.

Дэвлет 1976 – М.А.Дэвлет. Большая Боярская писаница. Москва. 1976.

Идэрхангай нар., 2022 – Т.Идэрхангай., С.Оргилбаяр., Б.Батчимэг., Л.Хүслэн., А.Намсрайжамц., Б.Баянсан., М.Мөнхжин., М.Батхишиг., Ж.Энхзул., Д.Аззаяа. Сяньбигийн үеийн бунхант булшны судалгаа буюу Гавилуй

уулын дурсгалт газарт явуулсан малтлага судалгааны ажлын товч үр дүнгээс. //Монголын археологи-2022, т.145-150. Улаанбаатар, 2022.

Кубарев и др. 2005 – В.Д.Кубарев., Д.Цэвээндорж., Э.Якобсон. Петроглифы Цагаан-салаа и Бага-Ойгура (Монгольский Алтай). Издательство Института археологии и этнографии СО РАН. Новосибирск–Улан-Батор–Юджин, 2005.

Кубарев 2011 – В.Д.Кубарев. Петроглифы Калбак-Таш I (Российский Алтай). Новосибирск, 2011.

Кызласов 1952 – Л.Р.Кызласов. Древнейшее свидетельство об оленеводстве. //Советская этнография. №2, т.39-49.

Новгородова 1984 – Э.А.Новгородова. Мир петроглифов Монголии. Москва, 1984.

Окладников 1980 – А.П.Окладников. Петроглифы Центральной Азии. Хобд-сомон Тэвш). Ленинград. 1980.

Ренчин 2006 – Б.Ренчин. Монгол бөөгийн дуудлага. Улаанбаатар 2006.

Санжмятав 1995 – Т.Санжмятав. Монголын хадны зураг. ШУА, Түүхийн хүрээлэн. УБ., 1995.

Санжмятав 1997 – Т.Санжмятав. Нүүдэлчдийн түүх соёлыг хадны зургаар судлах нь. //Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн зарим асуудал I. Редактор, Ш.Нацагдорж. УБ., 1997, т. 67-80.

Түвшинжаргал 2022 – Т.Түвшинжаргал. Тээвэрт үхэр ашиглах хэлбэр, түүний үүсэл хөгжил, уламжлал. “Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, т. 130-144. Эмхэтгэсэн Н.Батболд. Улаанбаатар, 2022.

Түвшинжаргал, Анхсанаа 2023 – Т.Түвшинжаргал, Г.Анхсанаа. Хадны зураг дахь үхэр тэрэгний дүрслэл. //Studia Archaeologica, Tom XLII, Fasc 9, т. 92-107. Institute of Archaeology, Mongolian Academy of Science. Улаанбаатар, 2023.

Түмэн нар. 2010 – Түмэн, Д., Эрдэнэбат, У., Эрдэнэ, М. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Сүмбэр, Билүүтийн талбайд явуулсан археологийн хайгуул, малтлага судалгааны тайлан. Монгол Улсын Их сургууль. Улаанбаатар, 2010.

Цэвээндорж 2019 – Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх. (Хоёрдугаар хэвлэл). Улаанбаатар., 2019.

Цэвээндорж, Баасандорж 2008 – Д.Цэвээндорж., Г.Баасандорж. Ловонгийн нурууны хадны зургийн дүрслэлийн тухай. // Монголын Говь-Алтайн хадны зураг. 2008, тал 80-112. Солонгосын Зүүн Хойд Азийн түүхийн сан/ Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн.

Цэвээндорж нар. 2010 – Д.Цэвээндорж., В.Д.Кубарев., Э.Якобсон. Шивээт хайрханы хадны зураг. ШУА-ийн Археологийн хүрээлэн. Улаанбаатар, 2010.

Цэрэндагва, Цэвээндорж 2016 – Я.Цэрэндагва., Д.Цэвээндорж. Далан түргэний хос толгойн хадны зураг. ШУА, Түүх, Археологийн хүрээлэн. Улаанбаатар., 2016.

Энхтүвшин, Санжмятав 2006 – Б.Энхтүвшин., Т.Санжмятав. Нүүдэлчдийн соёл ба монголын хүрэл зэвсгийн үеийн дурсгал. УБ., 2006.

Chen Fangyi 2012 – 陈芳怡《秦汉鹿图像研究》南京艺术学院硕士学位论文2012年。

Guo Yuhai 1996 – 郭玉海：《故宫藏镜》紫禁城出版社，1996年，157页。

Kortum 2018 – Kortum, R. Ceremony in Stone. The Biluut Petroglyph Complex: Prehistoric Rock Art in the Mongolian Altai. Нэпко хэвлэлийн газар. Улаанбаатар, 2018.

Laufer, B. 1917 – Laufer, B. The reindeer and its domestication. Memoirs of the American Anthropological Association, 4(2), 91–147.

Losey et al. 2020 – Losey, R. J., Nomokonova, T., Arzyutov, D. V., Gusev, A. V., Plekhanov, A. V., Fedorova, N. V., David. G. A. Domestication as Enskilment: Harnessing Reindeer in Arctic Siberia. Journal of Archaeological Method and Theory, 28(1), 197. 2020.

Rudenko 1970 – Rudenko, S.I. Frozen tombs of Siberia: The Pazyryk Burials of Iron Age Horseman. Translated by M.W. Thompson. University of California press. Berkeley & Los Angeles, 1970.

Sun Jianhua 2009 – 孙建华《内蒙古辽代壁画》文物出版社，2009年，北京。

Tan Xiao 2018 – 谭晓：《唐宋之际人物故事镜演变研究》陕西师范大学硕士毕业论文2018年，52页。

Tuvshinjargal & Makarewicz 2022 – Tuvshinjargal, T., Makarewicz, Ch. Cattle, Yaks, Traction, and the Bronze Age Spread of Pastoralism into the Mongolian Steppe. //Cattle and People: Interdisciplinary Approaches to an Ancient Relationship, Edited by Elizabeth Wright and Catarina Ginja. Lockwood Press. Columbus, GA. 2022.

Zhu Cunming, Liu Ji 2013 – 朱存明, 刘纪《汉画像“九头人面兽”研究》中国美术研究 \ 第1辑2013年, 21页。

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 09 сарын 30


Өгүүлэл засварласан: 2023 оны 11 сарын 17

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 12 сарын 01




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.


NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.




Зураг 1. Буга унасан зургийн тархалт: 1 – Калбак-Таши; 2 – Цагаан салаа, Бага-Ойгор; 3 – Шивээт хайрхан; 4 – Далан түргэний хос толгой; 5 – Цэнгэл хайрхан; 6 – Цагаан-Өтөг; 7 – Их Бэрх уул; 8 – Асган хонд; 9 – Ловонгийн нуруу, Ягаан орой; 10 – Салхитын хясаа; 11 – Чулуун онгоцот; 12 – Тэвш уул.




Зураг 2. Хакасын Боярын хадны зураг [Дэвлет 1976. Табл. V-1].
(Сэдэвтэй холбогдох хэсгийг дөрвөлжин хүрээнд хийж, томсгож үзүүлэв.)




Зураг 3. а – Говь-Алтай аймаг, Баянуул сум, Их Бэрх уул [Санжмятав 1997]; б – Тодорхойгүй [Санжмятав 1995]; с – Архангай аймаг, Чулуут голын Салхитын хясаа [Санжмятав 1995]; d – Өвөрхангай аймаг, Богд сум, Тэвш уул (Окладников 1980); e – Увс аймаг, Сагил сум, Цагаан-Өтөг [Цэвээндорж 2019]; f, h – Баян-Өлгий аймаг, Улаанхус сум, Шивээт хайрхан [Цэвээндорж нар 2010]; g – Говь-Алтай аймаг, Ловонгийн нуруу [Цэвээндорж, Баасандорж 2008]; i – Баян-Өлгий аймаг, Улаанхус сум, Цагаан салаа IV (Кубарев и др. 2005); j – Баян-Өлгий аймаг, Сагсай сум, Цэнгэл хайрхан (Бүрэнтөгс 2020); k – Говь-Алтай аймаг, Баян-Уул сум, Ягаан орой [Баасандорж 2018]; l – Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум, Далан түргэний хос толгой [Kortum 2018]; m – Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Бага-Ойгор III (Кубарев и др. 2005); n – ОХУ, Калбак-Таш [Кубарев 2011]; o – Баянхонгор аймаг, Өлзийт сум, Чулуун онгоцот; p – Говь-Алтай аймаг, Баян-Уул сум, Асган хонд.




Зураг 4. Тэрэгтэй нэг дор дүрслэгдсэн буга болон буга хөтөлсөн хүмүүсийн зураг. a – Архангай аймаг, Чулуут гол [Новгородова 1984]; b – Говь-Алтай аймаг, Баян-Уул сум, Ловонгийн нуруу [Баасандорж 2016]; c – Архангай аймаг, Чулуут голын Доод хужиртын ам, d – Елын ам, e – Салхитын хясааны урд тохой [Санжмятав 1995]; f – Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Эрдэнэ хайрхан [Түмэн нар. 2010:163].




Зураг 5. Зүүн хан улсын үеийн бунхны тоосгон дээрх буга унасан болон буга хөллөсөн тэрэгтэй хүмүүс [Zhu Cunming, Liu Ji 2013]



Зураг 6. Шандун мужийн Пинян сианаас олдсон чулуун дээр сийлсэн буга хөллөсөн тэрэгний зураг [Chen Fangyi 2012]



Зураг 7. а – Сичуан мужийн Пэнжюу хотын Жианкоу сианаас олдсон; в - Хэнан мужийн Енчэн хотоос олдсон [Chen Fangyi 2012]



Зураг 8. Шаньси мужийн Суйдэ сианаас олдсон бунхны хаалганы тотгон дээрх зураг [Chen Fangyi 2012]



a



b

Зураг 9. a – Тэргэнд буга хөллөж буй дүрслэлтэй Хятаны бунхны ханын зураг [Sun Jianhua 2009: 220];
b – Нуруу ачсан бугын дүрслэлтэй хүрэл толь (Монголын Үндэсний музей)